

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3.Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗАР”-ЫН
ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

2021.03.25 № 07/982
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан” -ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан”-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 76.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитаар нийт 9,857.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,035,728,199.62	14,547,221,918.18
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	70,641,992.51	125,694,901.39
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	70,641,992.51	125,694,901.39
31210	Төгрөг	70,641,992.51	125,694,901.39
31211	Төрийн сангийн харилцах	70,641,992.51	125,694,901.39
33	АВЛАГА	1,330,267,917.11	814,131,594.79
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	993,141,872.96	814,131,594.79
33300	Татаас, санхүүжилтийн авлага	337,126,044.15	0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	9,634,818,290.00	13,607,395,422.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	9,634,818,290.00	13,607,395,422.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,775,595.74	9,386,103.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,775,595.74	9,386,103.84
39200	Биет хөрөнгө	13,908,216.48	8,045,074.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,600,000.00	34,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,595,723.84)	(31,055,723.80)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	13,670,200.00	13,670,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,833,866.32)	(9,797,279.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,607,985.94	9,607,985.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,540,379.30)	(8,980,107.96)
39300	Биет бус хөрөнгө	1,867,379.26	1,341,029.26
39301	Программ хангамж	5,131,750.00	5,131,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,264,370.74)	(3,790,720.74)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,051,503,795.36	14,556,608,022.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	156,085,452.82	713,290,564.54
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	156,085,452.82	713,290,564.54
41300	Өглөг	117,265,050.10	126,755,579.70
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	0	5,067,488.00
41360	Бусад өглөг	117,265,050.10	121,688,091.70
41361	Байгууллагад төлөх өглөг	117,265,050.10	121,688,091.70
41400	Урьдчилж орсон орлого	38,820,402.72	586,534,984.84
41440	Бусад урьдчилж орсон орлого	38,820,402.72	586,534,984.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,895,418,342.54	13,843,317,457.48
51	Засгийн газрын хувь оролцоо	10,895,418,342.54	13,843,317,457.48
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	23,293,144.00	23,293,144.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	23,293,144.00	23,293,144.00
51200	Хуримтлагдсан үр дүн	10,864,523,078.89	13,812,422,193.83
51210	Өмнөх үеийн үр дүн	10,696,918,642.43	10,861,049,243.89
51220	Тайлант үеийн үр дүн	167,604,436.46	2,951,372,949.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,602,119.65	7,602,119.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,051,503,795.36	14,556,608,022.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,756,305,628.61	3,264,496,816.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,660,929,325.61	3,264,496,816.90
120	Нийтлэг татварын бус орлого	4,660,929,325.61	3,264,496,816.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,468,483,338.41	3,264,496,816.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,467,344,838.41	3,264,446,816.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,138,500.00	50,000.00
120009	Бусад орлого	1,192,445,987.20	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,095,376,303.00	0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,095,376,303.00	0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,095,376,303.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,336,104,900.15	261,923,866.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,336,104,900.15	261,923,866.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	170,270,013.58	256,423,866.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,451,969.13	175,863,416.66
210102	Нэмэгдэл	106,852,869.13	152,631,416.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,820,800.00	23,232,000.00
210104	Урамшуулал	5,778,300.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,323,418.30	23,737,726.40
210201	Тэтгэврийн даатгал	13,323,418.30	16,882,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	0	1,758,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	1,431,126.40
210204	Ажилгүйдлийн даатгал	0	148,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0	3,517,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,754,000.00	11,843,000.00
210401	Бичиг хэрэг	1,949,400.00	1,768,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,200,000.00	6,072,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,508,600.00	1,857,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,096,000.00	2,145,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,969,000.00	5,930,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,969,000.00	5,930,100.00
2107	Томилолт, зочны зардал	7,611,000.00	21,602,800.00
210702	Дотоод албан томилолт	7,611,000.00	20,345,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	1,257,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,505,826.00	4,999,852.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,004,500.00	4,100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,076.00	143,752.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,233,250.00	645,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,654,800.15	12,446,971.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	5,657,480.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	400,000.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,654,800.15	6,389,491.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,165,834,886.57	5,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	5,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	5,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,165,834,886.57	0
213306	Барьцаа техник хяналт	3,165,834,886.57	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,420,200,728.46	3,002,572,949.94
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,252,596,292.00	51,200,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,252,596,292.00	51,200,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	167,604,436.46	2,951,372,949.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,791,017,379.15	4,337,593,912.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,695,641,076.15	4,337,593,912.95
120	Нийтлэг татварын бус орлого	4,695,641,076.15	4,337,593,912.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,653,500,844.15	4,319,216,406.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,459,916,356.95	3,982,040,362.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,138,500.00	50,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,192,445,987.20	337,126,044.15
120009	Бусад орлого	42,140,232.00	18,377,506.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,095,376,303.00	0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,095,376,303.00	0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,095,376,303.00	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,763,950,121.15	4,282,541,004.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,763,950,121.15	4,282,541,004.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	180,510,687.43	258,331,360.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,022,187.43	175,863,416.66
210101	Үндсэн цалин	9,627,548.00	0
210102	Нэмэгдэл	100,408,639.43	152,631,416.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,986,000.00	23,232,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,753,200.00	23,737,726.40
210201	Тэтгэврийн даатгал	14,753,200.00	16,882,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	0	1,758,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	1,431,126.40
210204	Ажилгүйдлийн даатгал	0	148,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0	3,517,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,977,500.00	11,843,000.00
210401	Бичиг хэрэг	1,745,900.00	1,768,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,200,000.00	6,072,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,600.00	1,857,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,111,000.00	2,145,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,930,000.00	5,930,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,930,000.00	5,930,100.00
2107	Томилолт, зочны зардал	7,611,000.00	21,602,800.00
210702	Дотоод албан томилолт	7,611,000.00	20,345,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	1,257,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,143,826.00	4,999,852.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,054,500.00	4,100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,076.00	143,752.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,821,250.00	645,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,072,974.00	14,354,465.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,072,974.00	13,954,465.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	400,000.00
212	ТАТААС	3,079,340,003.00	4,018,709,644.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,079,340,003.00	4,018,709,644.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,079,340,003.00	4,018,709,644.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,504,099,430.72	5,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,138,500.00	5,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,138,500.00	5,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,502,960,930.72	0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	337,324,630.72	0
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	3,165,636,300.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	27,067,258.00	55,052,908.89
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	27,067,258.00	55,052,908.89
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	43,574,734.51	70,641,992.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	70,641,992.51	125,694,901.40

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,293,144.00	7,602,119.65	10,767,298,978.60	10,798,194,242.25
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	(70,380,336.17)	(70,380,336.17)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,293,144.00	7,602,119.65	10,696,918,642.43	10,727,813,906.08
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
Зарласан ногдол ашиг	0	0	0	0
Тайлант үеийн үр дүн	0	0	167,604,436.46	167,604,436.46
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,293,144.00	7,602,119.65	10,864,523,078.89	10,895,418,342.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,293,144.00	7,602,119.65	10,864,523,078.89	10,895,418,342.54
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
Өмчид гарсан өөрчлөлт	0	0	(3,473,835.00)	(3,473,835.00)
Зарласан ногдол ашиг	0	0	0	0
Тайлант үеийн үр дүн	0	0	2,951,372,949.94	2,951,372,949.94
2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	23,293,144.00	7,602,119.65	13,812,422,193.83	13,843,317,457.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,932,048,400.00	3,931,460,494.91	587,905.09	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	3,932,048,400.00	3,931,460,494.91	587,905.09	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	244,964,800.00	244,376,895.06	587,904.94	99.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,876,800.00	175,863,416.66	13,383.34	99.9
Нэмэгдэл	152,644,800.00	152,631,416.66	13,383.34	99.9
Унаа хоолны хөнгөлөлт	23,232,000.00	23,232,000.00	0.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,743,400.00	23,737,726.40	5,673.60	99.9
Тэтгэврийн даатгал	16,708,300.00	16,882,300.00	(174,000.00)	101.0
Тэтгэмжийн даатгал	1,758,800.00	1,758,800.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	1,407,000.00	1,431,126.40	(24,126.40)	101.7
Ажилгүйдлийн даатгал	351,800.00	148,000.00	203,800.00	42.0
Эрүүл мэндийн даатгал	3,517,500.00	3,517,500.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	11,843,700.00	11,843,000.00	700.00	99.9
Бичиг хэрэг	1,871,100.00	1,768,600.00	102,500.00	94.5
Тээвэр, шатахуун	6,072,000.00	6,072,000.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,600.00	1,857,400.00	63,200.00	96.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,980,000.00	2,145,000.00	(165,000.00)	108.3
Эд хогшил, урсгал засварын зардал	5,930,100.00	5,930,100.00	0.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	5,930,100.00	5,930,100.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	21,602,800.00	21,602,800.00	0.00	100.0
Дотоод албан томилолт	20,345,500.00	20,345,500.00	0.00	100.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,257,300.00	1,257,300.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,168,000.00	4,999,852.00	168,148.00	96.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,100,000.00	4,100,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	198,000.00	89,100.00	108,900.00	45.0
Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	143,752.00	54,248.00	72.6
Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	0.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.00	645,000.00	5,000.00	99.2
Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	400,000.00	400,000.00	50.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	400,000.00	400,000.00	50.0
ТАТААС	3,681,583,600.00	3,681,583,599.85	0.15	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,681,583,600.00	3,681,583,599.85	0.15	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,681,583,600.00	3,681,583,599.85	0.15	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,932,048,400.00	3,931,460,494.91	587,905.09	99.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,932,048,400.00	3,931,460,494.91	587,905.09	99.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,932,048,400.00	3,931,460,494.91	587,905.09	99.9

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын дунд үндэслэн шалгагдагч этгээдэд ажиллагсдад олгох урамшууллыг зохих хувь хэмжээгээр олгох, албан томилолт болон гэрээний төлбөр, бараа материалыг тооцооны дансаар дамжуулан зарлага болгох, төслийн эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад нь шилжүүлэх, тендер шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу цахимаар гүйцэтгэх, төсөл, арга хэмжээнд нэгдсэн төлөвлөгөө, төсөв боловсруулж, холбогдох зардлыг хууль тогтоомжийн дагуу зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 15-наас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Ц.Цэрэнхүү нар хариуцаж хэрэгжүүлэв.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 1/100 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх шинэчлэх зориулалтаар, үйлчилгээ явуулах эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;
- Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээний төрөл, хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь дотоод аудиторын орон тоо байхгүйгээс санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 313.1 сая төгрөгийн 1 хувь буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,505.1 сая төгрөгөөр буюу 31.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бусад эргэлтийн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	70.6	125.7	55.1
Авлага	1,330.3	814.1	(516.2)
Бусад эргэлтийн хөрөнгө	9,634.8	13,607.4	3,972.6
Үндсэн хөрөнгө	15.8	9.4	(6.4)
Нийт хөрөнгө	11,051.5	14,556.6	3,505.1
Өр төлбөр	156.1	713.3	557.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,895.4	13,843.3	2,947.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,051.5	14,556.6	3,505.1

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 125.7 сая төгрөг болж 55.1 сая төгрөгөөр өссөн нь төсөл, арга хэмжээний барьцаа хөрөнгө суутган авснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 814.1 сая төгрөг болж 516.2 сая төгрөгөөр буурсанд 337.1 сая төгрөгийн татаас, санхүүжилтийн авлага барагдсан нь нөлөөлжээ.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 13,607.4 сая төгрөг болж 3,972.6 сая төгрөгөөр өссөн нь төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон ашиглагч байгууллагад нь шилжүүлэх хөрөнгийг энэ дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 713.3 сая төгрөг болж 557.2 сая төгрөгөөр өссөн нь төсөл, арга хэмжээний 547.7 сая төгрөгийн барьцаа хөрөнгө байршуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13,843.3 сая төгрөг болж 2,947.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,491.8 сая төгрөгөөр буюу 51.7 хувиар, нийт зардал 6,275.6 сая төгрөгөөр буюу 95.2 хувиар буурсан нь орлогоо улсын төсөвт төвлөрүүлж, улсын төсвөөс буцаан санхүүжилтээ авдаг байсан төсвийн зохицуулалт өөрчлөгдөж орлогоороо зарлагаа санхүүжүүлдэг болсонтой холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,224.9 сая төгрөгөөр төлөвлөж, зарцуулахаар тооцон, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 292.9 сая төгрөгөөр бууруулж 3,932.0 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт хөтөлбөр арга хэмжээний 3,931.5 сая төгрөгийн санхүүжилтийг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан ба төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 161 мэдээллээс хугацаандаа оруулсан 154, хугацаа хоцроосон 7 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 291.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг хэрэгжүүлж, 9.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 9,634.8 сая төгрөгийн 1 албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	9.9	0	0.0	1	9.9	0
Албан шаардлага	2	9,925.8	1	291.0	1	9,634.8	50.0
Нийт	3	9,935.7	1	291.0	2	9,644.7	33.3

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,857.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчилд дараах албан шаардлага хүргүүлэв.
Үүнд:

1. Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 9,634.8 сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4.1.4-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-д "Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.19, 5.3.20-д зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулахыг хориглоно" гэж заасныг зөрчин 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба байгуулан 199.6 сая төгрөгийг цалин, НДШ-д зарцуулсан, тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэж заасныг зөрчин 23.5 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Барьцаа хөрөнгийн дансанд 2012 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 9.9 сая төгрөгийн гэрээнд заасан баталгаат хугацаа нь Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-д заасан хөөн хэлэлцэх хугацаанаас хэтэрсэн барьцааны үлдэгдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/1/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-д "Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.19, 5.3.20-д зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулахыг хориглоно" гэж заасныг зөрчин 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба байгуулан 199.6 сая төгрөгийг цалин, НДШ-д зарцуулсан, тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэж заасныг зөрчин 23.5 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.	223.1	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ Т.Халиунаа
2	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 9,634.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.	9,634.8	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ Т.Халиунаа
3	Барьцаа хөрөнгийн дансанд 2012 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 9.9 сая төгрөгийн гэрээнд заасан баталгаат хугацаа нь Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-д заасан хөөн хэлэлцэх хугацаанаас хэтэрсэн барьцааны үлдэгдэлтэй байна.	-	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Болор-Эрдэнэ Т.Халиунаа
ДҮН		9,857.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 445/10160055

Улаанбаатар хот

СНГ-2021/01/01А - 317С

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барьцаа хөрөнгийн дансанд 2012 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 9.9 сая төгрөгийн гэрээнд заасан баталгаат хугацаа нь Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-д заасан хөөн хэлэлцэх хугацаанаас хэтэрсэн барьцааны үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн нягтлан бодогч Т.Халиунаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
А.ДАВААДОРЖ
Ц.ЦЭРЭНХҮҮ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 26

№ 404/А0160056

Улаанбаатар хот

САГ - 2021/01/СА-ЗТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 9,634,818,290 (есөн тэрбум зургаан зуун гучин дөрвөн сая найман зуун арван найман мянга хоёр зуун ерэн) төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4.1.4-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэх асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн нягтлан бодогч Т.Халиунаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
А.ДАВААДОРЖ
Ц.ЦЭРЭНХҮҮ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherem\Alban_Shaardlaga\2021\0325auditin 2-R Газар2.Docx

001080504



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 406 / АД/60065

Улаанбаатар хот

СНГ - 2021/01/07А - ЗИТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба байгуулан 199,601,143 /нэг зуун ерэн есөн сая зургаан зуун нэг мянга нэг зуун дөчин гурван/ төгрөгийг цалин, НДШ-д зарцуулсан, мөн нэр бүхий 10 ажилтанд 23,509,100 /хорин гурван сая таван зуун есөн мянга нэг зуун/ төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-д "Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.19, 5.3.20-д зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулахыг хориглоно", Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх; биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн нягтлан бодогч Т.Халиунаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
А.ДАВААДОРЖ
Ц.ЦЭРЭНХҮҮ